

**МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН VI АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
ДААЛГАВАР С ХУВИЛБАР**

Хугацаа-60 минут

Нийт-20 оноо

Анги :

Сурагчийн нэр :

МОДОН ТОРХТОЙ БАЛ

Баавгай модон торх хийж зөгийн үүрний дэргэд тавив. Алаг зөгийнүүд эрэн цэцгийн дэлбээн дээр өдөржин бэлчээрлэж, оройхон үүрэндээ ирнэ. Үүрэн сархинагтаа амтат бал боловсруулж үүрнээсээ зөөж торхонд хийнэ. Баавгай ойгоор тэнэж торхны модаваад ирэхэд л амтат бал торхонд байдаг байжээ. Баавгай амтат балаа идсээр зун намрыг өнгөрөөж аглаг хөвч цасанд дарагдав. Баавгай ичээндээ оров. Баавгай хэнз яргуйтай уралдан ичээнээсээ гарч аглаг ой, аглаг цэцэгт ургамал, амтат балын эзэн эрэн зөгийнүүдээ эрээд эрээд олсонгүй. Дээрэнгүй эздийн огтолсон ойн хожуул ёрдойно. Баавгай дэргэд нь нулимс дуслуулан зогсоно.

Уншиж ойлгох чадварыг сорих даалгавар :

1. Эхийн сэдвийг олж тайлбарларлан бичнэ үү 2 оноо

- А. Эрэн зөгийнүүд Б. Алаг цэцэгт ой
В. Устаж буй байгаль Г. Ичээнээс гарсан баавгай

2. Эхийн гол санааг илэрхийлсэн хэсгийг олж дугуйлаад тайлбарлан бичнэ үү. 2 оноо

- А. Баавгай ичээндээ оров.
Б. Амтат бал торхонд байдаг байжээ.
В. Дээрэнгүй эздийн огтолсон ойн хожуул ёрдойж, баавгай дэргэд нь нулимс дуслуулан зогсоно.
Г. Эрэн зөгийнүүдээ эрээ эрээд олсонгүй.

3. Эхийн үйл явдлыг зөв дараалуулсан хэсгийг олоорой. 2 оноо

1. Дээрэнгүй эздийн огтолсон ойн хожуул ёрдойно.
2. Үүрэн сархинагтаа амтат бал боловсруулав.
3. Амтат балын эзэн эрэн зөгийнүүдээ эрээд эрээд олсонгүй.
4. Баавгай амтат балаа идсээр зун намрыг өнгөрөөв.

- А. 4.2.3.1 В.3.1.4.2. С.2.4.3.1 D.1.3.2.4

4. Цэгийн оронд тохирох нөхцөлийг нөхөж зөв бичээрэй. 2 оноо

Саран гий.... сайхан шөнө боловч хад байцын оргилд бараан сүүдэр тунар....

5. Тийн ялгалын нөхцөлөөр хувилсан жинхэнэ нэрийг тэмдэглээд тайлбарлан бичнэ үү 2 оноо

А. ирэхэд Б. үүрнээсээ В. Зөгийнүүд Г. Торхны

.....
.....

6. Зүрх цагаан өгүүллэгийн гол санааг өөрийн санаагаар дэлгэрүүлэн бичээрэй. 5 оноо

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

7. Монгол бичиг: Эхийг кирилл бичигт буулган бичээрэй 5 оноо

ᠭᠣᠮᠤᠮᠣᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ	ᠰᠤᠮᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ	ᠰᠤᠮᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ	ᠰᠤᠮᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ	ᠰᠤᠮᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ	ᠰᠤᠮᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ
----------------	--------------	--------------	--------------	--------------	--------------

.....
.....
.....
.....
.....

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
7 ДУГААР АНГИАС МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛЭЭР АВАХ АНГИ ДЭВШИХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

“Б” ХУВИЛБАР

Хугацаа: 60 минут

Нийт-20 оноо

Анги : Сурагчийн нэр :

Хүнд хоол

Нэг гүрний хаан ан гөрөө хийж яваад төөрч хэд хоног хоол ундгүй явж байгаад нэгэн овоохойд очжээ. Овоохойд ганц бие эмгэн байж гэнэ. Тэр эмгэн усанд шар будаа чанаж өгчээ. Тэр нь хаанд хүн болсоор идэж үзээгүй амттай хоол байжээ. Хаан ордондоо буцаж ирээд шар будаагаар янз бүрийн хоол хийлгэж идсэн боловч эмгэний хийж өгсөн хоол шиг амттай болохгүй байв. Хаан уурлаж: - Та нар тэр эмгэн шиг сайхан хоол хийж чадахгүй байна. Тэр эмгэнийг олж ир гэжээ. Эмгэн ирээд:- Миний хоол бол хүнд хоол юм. Ийм учраас хаантан минь та гурав хоног зоог барихгүй бай гэжээ. Хаан сайхан хоол идэх гэж гурав хоног хүлээжээ. Эмгэн усанд чанасан шар будаа өгөхөд хаан: - Яг ийм амттай сайхан хоол байсан юм гээд иджээ.

1. Эхийн гол санааг илэрхийлэх хэлцийг олоод тайлбарлан бичээрэй. 2 оноо

- A. Цадахад цагаан хурганы сүүл хатуу
Өлсөхөд өлөн бугын эвэр зөөлөн
 - B. Нуухыг нь авах гээд, нүдийг нь сохлох
 - C. Нэг чихээрээ оруулаад, нөгөө чихээрээ гаргах
 - D. Ууж идэхдээ уургын морь
-
.....
.....

2. Эхийн хэсгүүдийн зөв дарааллыг олоорой. 2 оноо

- A. Хаантан төөрчээ, овоохойд очжээ, амттай хоол идэв, ордондоо буцав, хоол таалагдсангүй, гурав хоног хоолгүй байв, эмгэн ирэв, амттай сайхан хоол байв.
- B. Овоохойд очжээ, хаантан төөрчээ, амттай хоол идэв, ордондоо буцав, хоол таалагдсангүй, гурав хоног хоолгүй байв, эмгэн ирэв, амттай сайхан хоол байв.
- C. Хаантан төөрчээ, овоохойд очжээ, амттай хоол идэв, ордондоо буцав, хоол таалагдсангүй, эмгэн ирэв, гурав хоног хоолгүй байв, амттай сайхан хоол байв.
- D. Овоохойд очжээ, хаантан төөрчээ, амттай хоол идэв, ордондоо буцав, хоол таалагдав, гурав хоног хоолгүй байв, эмгэн ирэв, амттай сайхан хоол байв.

3. Бүгд тэмдэг нэр бүхий хэсгийг олоорой. 2 оноо

- A. хаан, сайхан B. амттай хоол C. ганц, идэв D. амттай, сайхан

4. Алдаатай өгүүлбэрийг зөв болгон найруулж бичээрэй. 2 оноо

Өөдөөс харан сууж байгаа хүүхнийг зориуд ичээж, **чанга чанга** ширтэж байв.

.....
.....
.....

5. Дараах өгүүлбэрийн бүтээврийг нөхөж бичнэ үү? 2 оноо

Очир өглөө бос..., морио эмээл..., адуун... яв...

6. П.Пүрэвсүрэнгийн “Бурхан богд аав” өгүүллэгийн гол санааг өөрийн үгээр бичнэ үү? 5 оноо

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7.Үндэсний бичгээс кирилл бичигт буулгаарай. 5 оноо

ᠯᠢᠮᠤᠯᠠᠭ
ᠮᠤᠨᠤᠯᠠᠭ
ᠯᠢᠮᠤᠯᠠᠭ
ᠮᠤᠨᠤᠯᠠᠭ

.....

.....

.....

.....

.....